

**“Оюутны хөгжил” - ийн хөтөлбөрт өгсөн санал:**

**1. Тайлагнах гэдгийг тодорхой болгох.**

А. Хөтөлбөрийн гурав дахь хэсэгт байгаа. Мөн нэмж аймгийн ИТХ-д тайлагнах заалтыг орууллаа.

**2. Оюутанд олгох тэтгэлэг, шагналыг тодорхой болгох:**

А. Жил бүрийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр батлагдсан төсвийн хязгаарт багтаж оюутны тоог тогтоох тул, хөтөлбөрт шууд тоогоор тавих боломжгүй.

В. Хөтөлбөрийг үндэслэж, шагнал, тэтгэлэг, дэмжлэг авах оюутныг шалгаруулах тодорхой шалгуур үзүүлэлтийг боловсруулж, оюутнуудад нээлттэй байлгана.

**3. Хөтөлбөр хэрэгжүүлж эхлэх үеийн гарааны нөхцөл байдлыг тодорхой болгож, хүрэх үр дүнг тодорхойлох.**

А. Аймгийн 3 сургуулийн нийт төгсөгчдийн 40% нь шууд ажлын байртай болж байна. Сургуулиуд өөрсдөө ийм судалгаагүй байдаг.

В. Энэ хөтөлбөр нь зөвхөн Дорнод аймгийн 3 сургуулиар хязгаарлагдахгүй Дорнод аймгийн харьяатай Улаанбаатар хот болон бусад аймаг, улс оронд суралцаж байгаа оюутнуудад хамааралтай.

С. Манай аймагт ийм төрлийн нэгдсэн судалгаа өмнө нь огт хийж байгаагүй, одоо ерөнхий боловсролын сургуулиуд, оюутны холбоод, мэргэжлийн байгууллагуудтай хамтраад, одоо суралцаж байгаа оюутнуудын мэдээллийн сантай болно. Судалгааг эхний 6 сардаа багтаан хийж, гарааны үзүүлэлтээ тодорхойлж, мөн хүрэх үр дүнгээ тоон болон чанарын үзүүлэлттэй болгоно. Мөн хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөтэй болно.

**4. Хүрэх үр дүнг зоригтой сайн тавьж өгөх:**

6.3 –т: Оюутнууд нь эрүүл мэнд, амьдралын буруу хэвшлийн сөрөг тоон үзүүлэлттгүй байна. / бууруулна гэснийг өөрчлөв/

**5. Оюутныг төгсөөд гарахаар нь ажлын байраар хангах талын ажлыг оруулах:**

Оюутны хөгжил хөтөлбөр нь:

А. оюутан болохын өмнө суралцах мэргэжлээ зөв сонгох

В. Суралцаж байхдаа сайн суралцах, шууд ажлын санал авахуйц хэмжээнд суралцах

С. Ажлын байранд дадлагажих, ахмад үеэсээ суралцах, үргэлжлүүлж мэргэшиж суралцах зэрэгт анхаарсан ажлуудыг төлөвлөж ажиллана.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн  
ээлжит 04 дүгээр хуралдааны  
03 дугаар тогтоолын хавсралт

## ДОРНОД АЙМГИЙН “ОЮУТНЫ ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨР

### Нэг: Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2016 оны 178 дугаар тогтоолоор батлагдсан “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөр, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, “Аймгийн Засаг даргын 2016–2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр” бодлогын бичиг баримтад: Оюутнуудын сурч, хөгжих, хөдөлмөрлөх, нийгмийн оролцоо, үүрэг хариуцлагыг нь дээшлүүлэх, төгсөөд ажлын байраар хангагдахад орон нутгийн зүгээс бодлогоор дэмжлэг үзүүлэх заалтууд тусгагдсан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит 3 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Оюутны хөгжлийн хөтөлбөр” хэрэгжүүлэх заалт батлагдсан.

Дорнод аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт, хөрш зэргэлдээ улс орны их дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургуулиудад аймаг, орон нутгийн төсөв, аймгийн Хөгжлийн сангийн дэмжлэгээр, оюутныг сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй нөхцлөөр сургах, улс, бүс, орон нутгийн чанартай урлаг, спортын болон бусад уралдаан, тэмцээнд оролцуулах зэрэг дэмжлэгийг үзүүлсээр ирсэн.

Дорнод аймаг нь зүүн бүс нутагтаа мэргэжилтэн бэлтгэдэг Дорнод их сургууль, Политехник коллеж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй.

Эдгээр гурван сургууль нийт 50 гаруй төрлийн мэргэжлээр, жилд дунджаар 700 гаруй боловсон хүчнийг бэлтгэн төгсгөдөг. Төгсөгчдийн 40% нь ажлын байраар хангагдаж байна. 2016-2017 оны хичээлийн жилд Дорнод аймагт нийт 1873 оюутан, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 11 суралцагч байна. Сургуулийнхаа оюутны байранд нийт 238 оюутан амьдардаг.

“Оюутны хөгжил” хөтөлбөр нь:

- Дорнод аймагт мэргэжлийн сургалт явуулж буй сургуулиуд нь бүс, орон нутагт нэн шаардлагатай ажил мэргэжлээр хүний нөөцийг бэлддэг байх,
- Орон нутаг, бүс нутгийн хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд маргаашийн албан хаагч болох, өнөөдрийн оюутаны оролцоог нь идэвхжүүлэх,
- “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх сургууль бүрийн бодлогыг орон нутгийн хөтөлбөрөөр нэгтгэх
- Оюутан, залуусыг дэмжсэн бодлогын хэрэгжилтийг хангах ач холбогдолтой болно.

Дорнод аймгийн 2016-2025 оны **ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ**

**ОЮУНЛАГ, БОЛОВСРОЛТОЙ ЗАЛУУСААРАА УЛСДАА ТЭРГҮҮЛЭХ БАЙР СУУРИА ХАДГАЛНА.**

### ХОЁР: ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

**ОРЛОГОТОЙ, ОЮУНЛАГ, ӨРСӨЛДӨХ ЧАДАМЖТАЙ ОЮУТНЫ ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ**

## Гурав: Удирдлага, зохион байгуулалт, тайлагналт

*Аймгийн Засаг даргын Тамгийн газрын Нийгмийн бодлогын хэлтэс:* Хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих, оролцогч талуудын зохицуулалт хийх, удирдлагаар хангах үүрэг хүлээнэ.

*Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газар:* Сургууль, оюутны холбоо төрийн бус байгууллагатай хамтран хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, гүйцэтгэл, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөл, **аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана. /нэмсэн/** Жил бүрийн төлөвлөгөө, төсвийг аймгийн Засаг даргаар батлуулна. Хэрэгжилтийг бусад хөтөлбөртэй уялдаа холбоотой хэрэгжүүлж байна.

*Дорнод их сургууль, Политехник коллеж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв:* Хөтөлбөр хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцогч, хамтрагч байна.

*Зүүн бүсийн оюутны холбоо төрийн бус байгууллага:* Сургуулиудын оюутны холбоодыг идэвхжүүлэх, хамтын ажил, эргэх холбоог тасралтгүй байлгах, хөтөлбөр хэрэгжүүлэх, үр дүнг аймгийн Засаг даргад тайлагнах үүрэгтэй.

### Дөрөв: Хамрах хүрээ

- Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Дорнод их сургууль, Политехник коллеж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, эдгээр сургуульд суралцаж байгаа оюутан залуус
- Дорнод аймгийн үндсэн харьяат оюутан залуус нь хөтөлбөр хэрэгжилтэд идэвхтэй хамтран оролцогч нь байна.

### Тав: Зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

**5.1. Зорилт-01. “ОРЛОГОТОЙ ОЮУТАН” үндэсний хөтөлбөрийг орон нутгийн нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:**

5.1.1. “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөр хэрэгжилтэд орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагыг идэвхтэй оролцуулна.

5.1.2. Ажил эрхлэх хүсэлтэй оюутнуудад сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна.

5.1.3. “Оюутны хөдөлмөрийн бирж”-ийг ажиллуулна.

5.1.4. Оюутны төсөл хөтөлбөрийг дэмжинэ.

5.1.5. Оюутны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээнд маркетингийн дэмжлэг үзүүлнэ.

5.1.6. Суралцаж байгаа мэргэжлээрээ дадлагажих, ахмад үе, туршлагатай, мэргэшсэн албан хаагчдаас суралцах, боломжийг нэмэгдүүлнэ.

**5.2. Зорилт-02. “Эрүүл оюутан” Оюутан нь эрүүл чийрэг бие бялдартай, амьдралын зөв үйлтэй иргэн байх зорилтын хүрээнд:**

5.2.1. Оюутан бүрийг аймгийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвд харьяалалтай болгож, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагддаг, эрүүл мэнд, амьдралын зөв хэвшил, гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамруулна.

5.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй оюутныг үе тэнгийнхний хамт сурч хөдөлмөрлөх, нийгмийн идэвхтэй иргэн байхыг нь дэмжинэ.

5.2.3. Оюутан гэр бүлийн хүүхдийг цэцэрлэг, сургуульд хамруулах, хямд үнэтэй түрээсийн байрны орон нутгийн хөтөлбөртэй болно.

5.2.4. Оюутны холбоод хамтарч, бүх нийтийн гүйлтийг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, багийн спортын арга хэмжээнд идэвхтэй оролцогч байна.

5.2.5. Оюутнуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх соёл, урлаг, спортын сайн дурын хамтлаг, клубуудын үйл ажиллагааг дэмжинэ.

5.2.6. Оюутан нь аймаг, бүс нутаг, үндэсний түүх, өв соёл, хөгжил, бүтээн байгуулалтыг олон нийтэд сурталчлан таниулдаг байна.

**5.3. Зорилт-03. “Оюунлаг оюутан” - Оюутан нь бүс нутаг, үндэсний хэмжээнд танигдсан, цаашлаад олон улсад өрсөлдөх чадвартай болох зорилтын хүрээнд:**

5.3.1. Хүүхэд, залуусыг мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлж, бүс, орон нутагт нэн шаардлагатай ажил мэргэжлийн чиг баримжаа, мэргэжил сонголтын сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулна.

5.3.2. Орон нутагт хэрэгцээтэй хүний нөөцийн бодлого, чиглэлийг жил бүр олон нийтэд танилцуулдаг байна.

5.3.3. Оюутан нь эрүүл мэнд-нийгмийн даатгал зэрэг хууль эрх зүйн талаар болон аймаг, бүс нутаг, үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрийн талаарх мэдлэгтэй байлгахад анхаарч ажиллана.

5.3.4. Орон нутгийн бодлого, хамтын ажиллагааны гэрээний дагуу суралцагч, зорилтод бүлгийн оюутан, манлайлагч оюутанд орон нутгаас сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

5.3.5. Орон нутаг, бүс нутгийн хөгжил, инновацид суурилсан мэдлэгийг баялаг болгох судалгаа, илтгэл, эрдэм шинжилгээний хурал, бүтээлч ажлуудыг зохион байгуулна.

5.3.6. Манлайлагч, бүтээлч, үндэсний хэмжээнд танигдсан шилдэг оюутанд “Засаг даргын нэрэмжит” урамшуулал олгоно.

**5.4. Зорилт-04. “ХАРИУЦЛАГАТАЙ ОЮУТАН” Оюутан бүр эко орчинг нэмэгдүүлэх, хүмүүнлэгийн үйлс, нийгмийн идэвх оролцоотой байх зорилтын хүрээнд:**

5.4.1. Дорнод аймагт суралцаж байгаа, аймгийн үндсэн харьяат оюутны нэгдсэн мэдээллийн сантай болж, оюутнуудын олон нийтийн байгууллагууд бүтээлчээр хамтран ажилладаг байна.

5.4.2. Оюутны холбоо нь оюутнаа дэмждэг, чадавхижуулж идэвхжүүлдэг, манлайлагч, сургагч, чиглүүлэгч оюутнуудын тасралтгүй залгамж холбоотой болно.

5.4.3. “Оюутан цэрэг”, “Оюутан цагдаа” төсөл, хөтөлбөрийг жил бүр хэрэгжүүлнэ.

5.4.4. Эко орчинг нэмэгдүүлэх оюутны санаачлага, оролцоог дэмжиж, оюутан нь эх дэлхийгээ хайрлах, уламжлалт ёс заншлаа дээдлэгч, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг түгээгч байна.

5.4.5. Оюутны санаачилсан хүмүүнлэг, нийгмийн хариуцлагын бүтээлч төсөл, арга хэмжээг дэмждэг байгууллага, аж ахуйн нэгжийг нэмэгдүүлнэ.

5.4.6. Төгсөгчдийн эргэх холбоог сайжруулж, сургуулиудын орон нутгийн хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд оруулж байгаа чадамж, бүтээмжийг тодорхойлдог болно.

**Зургаа. Хүрэх үр дүн:**

6.1. “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөр хэрэгжилтийн үнэлгээгээр хангалттай үнэлэгдэж, оюутны орлого жил бүр өсөн нэмэгдсэн байна.

6.2. Дорнод аймгийн оюутнууд нь үндэсний хэмжээнд үзүүлсэн амжилт өссөн байна.

6.3. Оюутнууд нь эрүүл мэнд, амьдралын буруу хэвшлийн сөрөг тоон үзүүлэлтгүй байна. /бууруулна гэснийг өөрчлөв/

6.4. Оюутны нийгмийн идэвх, оролцоо сайжирсан, орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр дээшилсэн байна.

**Долоо. Хөтөлбөр хэрэгжилтийн хяналт-үнэлгээ:**

- 7.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хяналт-үнэлгээг жил бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс,
- 7.2. Хөндлөнгийн хяналт, мониторинг сургуулиудын удирдах зөвлөлд орсон орон нутгийн төрийн төлөөлөл нь жилд 2-оос доошгүй удаа хийж байна.
- 7.3. **Сургууль, оюутны холбоо:** бүр нь “Оюутны хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвөө өөрийн сургуулийн онцлогт суурилан баталж хэрэгжүүлнэ

**Найм. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа: 2017-2020 онд хэрэгжүүлнэ.**

**Ес: Хөтөлбөрийн санхүүжилт:**

- Улсын болон аймаг орон нутгийн төсөв
- Хандивлагч орон, олон улсын байгууллагын хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, зээл, тусламж, хандив.
- Төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив.
- Бусад эх үүсвэр

—00—00—